

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр (Хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1 дүгээр байр), 107 тоот хурлын танхимд хуралдав.

ХУРЛЫН ИРЦ: Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал ирээгүй, 20,147,438 ширхэг хувьцааг төлөөлж 6 хүн итгэмжлэлээр, 1496 ширхэг хувьцаа эзэмшигч 11 хүн өөрийн биеэр нийт 20,148,934 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96,06 хувийн ирцтэй хуралдав.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

Д/д	Нэр	Албан тушаал
1	Д.Даваадаш	Хурал зохион байгуулах комиссын дарга, “Багануур” ХК-ийн Хүний хөгжил, судалгаа эрхэлсэн дэд захирал
2	Г.Соёлмаа	Хурал зохион байгуулах комиссын нарийн бичиг “Багануур” ХК-ийн бизнес, хамтын ажиллагаа хариуцсан төлөөлөгч
3	Б.Батболд	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн Захиргаа хүний нөөц удирдлагын хэлтсийн дарга
4	Ж.Болд-Эрдэнэ	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн Санхүү эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга
5	Б.Одгэрэл	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн хуулийн зөвлөх
6	С.Одончимэг	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн Хэвлэл мэдээллийн ажилтан
7	Э.Чулуунзориг	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн гүйцэтгэх захирлын туслах
8	П.Нямхүү	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн хуралдааны менежер
9	Б.Гантулга	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн бэлтгэн нийлүүлэгч, жолооч
10	А.Ганболор	Хурал зохион байгуулах комиссын гишүүн “Багануур” ХК-ийн ажилтан
11	Б.Хажидмаа	Тооллогын комиссын дарга, “Багануур” ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны дарга

12	Б.Наранцэцэг	Тооллогын комиссын гишүүн, "Багануур" ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн
13	М.Дондогдулам	Тооллогын комиссын гишүүн, "Багануур" ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

1. "Эрдэнэс Монгол" ХХК-ийг төлөөлж Нэгдлийн чанар бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбаян, Хууль эрх зүйн газрын дарга Б.Гэрлээ, Хууль эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Б.Тэнгис
2. "Монголиан нэшнл коал корпорэйшн" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Шижир, М.Отгонбаяр
3. Бусад хувьцаа эзэмшигч нар

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ТАНИЛЦУУЛСАН:

1. Д.Түвшинжаргал "Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
2. Б.Наранбаатар "Багануур" ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч
3. Ч.Дондогмаа Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга
4. Б.Чойжил Төлөөлөн Удирдах зөвлөлийн аудитын хорооны дарга
5. Б.Жавхлан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга,
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Хажидмаа /Тооллогын комиссын дарга/ : "Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулав. Хуралдааны ирц бүрдсэн тул хурлыг хуралдуулахыг зөвшөөрч байна

Ч.Дондогмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/: 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаартай "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах" тогтоолыг уншиж танилцуулан өнөөдрийн хуралдааны даргалагчаар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл Д.Ядамжавыг томилсныг танилцуулав.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэг, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалыг тус тус танилцуулав. Нэгдүгээр асуудал болох компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг "Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Түвшинжаргал танилцуулна уу.

Д.Түвшинжаргал /Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Компанийн 2023 оны санхүүгийн тайланг танилцуулав. Үүнд:

Компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад хүчин зүйлс: Гадаад валютын ханш жил бүр нэмэгдэж байгаагаас шалтгаалж компанийн худалдан авалтын өртөг нэмэгдэж байна. Түүнчлэн 2024 онд Монгол улсын инфляц 9 хувьд хүрсэн буюу өмнөх оноос 1.1 хувиар нэмэгдсэнээс шалтгаалж компанийн үйл ажиллагааны зардалд мөн нөлөөлж байна. Мөн туслах материалын нэгж үнэ 2022 он буюу ковид цар тахлаас хойш буугаагүй нь зардлын өсөлтөд нөлөөлж байна.

Цаг агаарын хувьд 2024 он олон жилийн дунджаас илүү бороо, цастай байснаас шалтгаалж ажлын бүтээл алдагдсан. Тухайлбал борооноос шалтгаалж 232,000 м3, цаснаас шалтгаалж 226,900 м3 ажлын бүтээл тус тус алдаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 1714 цаг зогссон. Түүнчлэн их хэмжээний цас борооны нөлөөгөөр халтиргаа гулгаа үүсэх, зумфны усны түвшин нэмэгдэх зэрэг нөхцөл байдал үүсэж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн.

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт: 2024 онд компанийн зорилтот түвшний үндсэн 17 үзүүлэлтээс 11 зорилт 100 ба түүнээс дээш хувьтай биелсэн, 3 зорилт 95 ба түүнээс хувьтай биелсэн, 3 зорилт 80 ба түүнээс дээш хувьтай биелж, нийт дүнгээрээ 97.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. 2024 онд түүхэн дээд амжилт буюу 4.9 сая тонн нүүрс олборлон борлуулсан, дунд хугацааны техник эдийн засгийн үндэслэлийг батлуулан ажилласан, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Эрдэнэс Монгол" ХХК-иас 12 тэрбум төгрөгийн зээлийг авч ажилласан. Гэвч уулын ажлын үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй үүнд дээр дурдсан цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан ажлын бүтээл алдагдсан болон хөрс тээврийн 3 машин, техникийн тендер шалгаруулалт амжилтгүй болж, төлөвлөсөн хугацаа болох 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдөр биш 10 дугаар сарын 1-ны өдрөөс ажиллах эхэлсэн буюу 3 сарын хугацаа алдсанаас шалтгаалсан. Мөн борлуулалтын орлого, хуримтлагдсан өр төлбөр барагдуулалт, хөрөнгө оруулалт, байгаль орчны үзүүлэлтүүд зорилтот түвшин хүрч чадаагүй. Манай компани зөвхөн Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудаас гадна төрийн болон хувийн хэвшлийн орон нутгийн бусад станцуудад тодорхой хэмжээнд борлуулалт хийдэг.

Эдийн засгийн үзүүлэлт: 2024 онд 242,4 тэрбум төгрөгийн орлого олж, 240,2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 11.4 тэрбум төгрөгийг хэмнэж, 1.7 тэрбум төгрөгийн

ашигтай ажиллаж төлөвлөсөн алдагдлыг 9.0 тэрбум төгрөгөөр бууруулсан. Гэвч хуримтлагдсан өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 15.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 258.7 тэрбум төгрөгт хүрсэн. Үүний шалтгаан нь татварыг хугацаанд нь төлөөгүйтэй холбоотой татварын өр төлбөрийн асуудал юм. Цаашид толгой компани, Монгол Улсын Засгийн газартайгаа хамтарч өр төлбөр бууруулах арга хэмжээг авч ажиллах болно. Нөгөө талдаа Бэлтгэн нийлүүлэгчид болон богино хугацаат өр төлбөрүүдээ шат дараатай бууруулж байгаа. Мөн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хуримтлагдсан өр төлбөрийг 2024 онд төлж барагдуулсан буюу 24 тэрбум төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан. Цаашид үнэ тарифын чиглэлээр зөвлөлдөх уулзалтуудыг хийж ажилласан.

Бусад мэдээлэл: 2024 онд нийт 105 тендер сонгон шалгаруулалт зарлаж, 102 тендерт шалгаруулалт амжилттай болж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 1,078.9 сая төгрөгийн бараа материалыг Үндэсний үйлдвэрлэгчдээс худалдан авсан. Түүнчлэн 2024 онд нийт 169,074.3 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 138,138.9 сая төгрөгийн худалдан авалт хийж 30,935.4 сая төгрөг буюу 81.7 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Ажиллах хүчний хувьд 2024 онд нийт 127 ажилтан чөлөөлөгдсөн бөгөөд өөрийн хүсэлтээр гарч буй ажилчид өмнөх оноос 50 хувь буурч 37 ажилтан өөрийн хүслээр гарсан байна. Мөн 62 хүн тэтгэвэрт гарсан бөгөөд үүнээс шалтгаалж хүний нөөцийн 47 хувийг 36-45 насны ажилчид бүрдүүлж буй буюу ажилчдын дундаж нас залуужиж байна. Манай компани 20 жилийн өмнөх орон тоогоороо буюу 1122 ажилтантай өнөөдөр хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Техник ашиглалтын хувьд 2024 онд хөрс тээврийн комацу 785 автосамомвал 3 ширхэг, WD600 дугуйт бульдозер 1 ширхэг нийт 17.8 тэрбум төгрөгийн техникийн шинэчлэлтийг өөрийн хөрөнгөөр хийлээ. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хувьд 2024 онд үйлдвэрийн осол, авааргүй ажилласан, түүнчлэн ISO 45001:2018 гэрчилгээ сунгасан, эрүүл мэндийн үзлэгт нийт 1025 ажилтныг хамруулсан. Мөн нийт 50.7 тэрбум төгрөгийн төсөв төвлүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигч нарт 495.4 сая төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нарт хуваарилсан. Мөн Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд компанийн үйл ажиллагааны үзүүлэлтээр тэргүүлж "Алтан эрдэнийн цом" шагнал авсан.

2025 онд хийгдэх голлох ажлууд: 2025 онд технологи дамжлага 3-ийг яаралтай барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Түүнчлэн Багануур УТП-д нүүр нийлүүлэх, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. Түүнчлэн санхүүгийн зохистой харьцааг бий болгоход голчлон төвлөрч ажиллах болно. Уурхайн нийт ажилтнууд, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хамтын хүчээр 2024 онд үр ашигтай ажиллаж чадлаа, та бүхэнд баярлалаа.

Хуралд танилцуулсан материалыг хавсаргав.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн аудитын хорооны дарга Б.Чойжил танилцуулна. Та танилцуулгаа хийнэ үү.

Б.Чойжил /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/: Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлт болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр тогтоолыг танилцуулав.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигч нарт Компанийн 2024 оны санхүүгийн тайлантай холбоотой асуулт, санал байна уу ?

Э.Шижир / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: компани олон жилийн дараа анх удаа ашигтай ажилласан гэж тайлбарлалаа, гэтэл уулын ажил зорилтот хэмжээнд хүрээгүй байна. үүний шалтгааныг цаг уур болон тендер шалгаруулалт удааширсантай холбоотой гэж тайлбарлалаа. Тэгвэл энэ хоцорсон хөрс хуулалт болон уулын ажлыг 2025 онд нөхөж хийх үү ? нөхөж хийсэн тохиолдолд 2025 оны төлөвлөлтөд нөлөөлөх үү ? уулын ажил нь хойшоо сунаад дахиад 2025 онд уулын ажил зорилтод хүрэхгүй байх эрсдэл байгаа юу ?

Д.Түвшинжаргал /Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Эрчим хүчний нүүрсний үнэ 12 дугаар сарын 01-ны өдөр нэмэгдсэн энэ нь тодорхой хэмжээнд 2024 онд ашигтай ажиллахад нөлөөлсөн, 2025 онд гадаад валютын ханш огцом өсөхгүй бол бид 2025 онд ашигтай ажиллаад явах боломжтой бөгөөд уулын ажлын хоцрогдлыг 2025 оны 03 дугаар гэхэд бүрэн нөхсөн учир 2025 оны төлөвлөгөөнд хоцрогдол үүсэхгүй байх гэж таамаглаж байна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигч нарт Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбоотой өөр асуулт, санал байна уу ?

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: За байхгүй бол асуулт саналыг тасаллаа. Саналын хуудас тараагдсан уу хурал зохион байгуулагч нараа ? Саналын хуудаснуудыг хувьцаа эзэмшигч нарт яаралтай тараагаарай. Хугацаа хэмнэх үүднээс дараагийн асуудалдаа оръё тэр хооронд хурал зохион байгуулагч нар саналын хуудас тараагаарай. За ингээд хэлэлцэх асуудал 2 Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг "Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Наранбаатар танилцуулна.

Б.Наранбаатар /"Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч/: Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав. Үүнд:

Хараат бус аудитын дүгнэлт: Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын байгууллагаас томилсон Мишээл-Од санхүүгийн аудитын

байгууллага аудит хийж, үнэлэлт дүгнэлт хийсэн. Өмнөх жилд Компанийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хязгаарлалттай дүгнэлтийг хөндлөнгийн байгууллагаас өгсөн тул 2024 оны 04 дүгээр сард Гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж аудитын дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх өөрчлөлтгүй дүгнэлт авахыг зорилго болгон ажилласан. Үүний үр дүнд 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд "Өөрчлөлтгүй" буюу зөрчилгүй дүгнэлт авсан.

Өөрчлөлтгүй дүгнэлтэд дараах гол хэсгүүд тусгагдсан: Санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна гэж дүгнэсэн.

Асуудлын онцолсон хэсэг: Хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай машин, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч, сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгүүр болон их засваруудыг хийж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна гэж онцолсон.

Аудитын гол асуудал: Тайлант онд нийт 244,296.3 сая төгрөг орлого олж, 251,657.0 сая төгрөг зардал гарган 7,360.7 сая төгрөг алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 241,590.0 сая төгрөг орлого олж, 239,938.4 сая төгрөг зардал гарган 1,651.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна гэж асуудлыг тодорхойлсон

Бусад асуудлын хэсэг: Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 588 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний үнийг 43,310.00 төгрөгөөр баталсан байсныг 2024 оны 694 дүгээр тогтоолоор 54,091.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна.

Санхүүгийн тайлангийн голлох өөрчлөлт: Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 3.8 тэрбум төгрөгөөр өсөж 6.3 тэрбум төгрөг болсон. Үүний гол шалтгаан нь 2024 оны 12 дугаар сард арилжааны банкны төлбөр тооцооны үлдэгдэл компанийн дансанд шилжсэнтэй холбоотой. Авлагын хэмжээ бол өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр буурч 6.6 тэрбум төгрөг болсон. Бараа материалын хувьд томоохон өөрчлөлт ороогүй, харин урьдчилж төлсөн зардал 2.3 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүний шалтгаан нь 2024 онд хийгдэх барилгын ажил дээр гүйцэтгэл гараагүй тул ингэж өссөн байгаа. Үндсэн хөрөнгө бол оны эцсээс 4.3 тэрбумаар буурч 201,1 тэрбум төгрөг болсон. Үүний шалтгаан нь манай компанид бүртгэлгүй байсан 8 газрыг бүртгэлд тусгасан мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 16 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэлжүүлснээс шалтгаалсан. Өр төлбөрийн хувьд оны эхнээс 16 тэрбум төгрөгөөр өсөж 258.6 тэрбум төгрөгийн өр төлбөртэй болсон. Үүний шалтгаан нь татварын өр төлбөр буюу хугацаандаа татвараа төлөөгүйн алданги шүүхээр шийдэгдэж өр төлбөр дээр

бичигдсэн байгаа. Эздийн өмч нийт дүнгээрээ дүн 15 тэрбум төгрөгөөр буурч, 6.8 тэрбум төгрөг болсон. Үүний гол шалтгаан нь 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд татварын шалгалт хийгдсэн тус шалгалтаар татварын өр төлбөрийг хугацаандаа төлөөгүй гэж 11 тэрбум төгрөгийн алдангийг ногдуулсан.

Аудитын тайлангийн албан шаардлага, зөвлөмжүүд: Аудитаар 845.1 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 222.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 618.6 сая төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 3.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. Аудитаар илэрсэн 845.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 3,774.8 сая төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан.

- **Төлбөрийн акт 1.** Дундаж цалинг буруу тооцож 10 хүнд 627.7 мянган төгрөг илүү олгосон.
- **Албан шаардлага 3.** Бараа материалын хяналтын тооллогоор 4.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг эргэхийн редукторын араа удаан хадгалагдсан хуучин бараа байна. Үндсэн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудал, 4 төрлийн 217.8 сая төгрөгийн барааг их хэмжээгээр нөөцөлсөн асуудал
- **Хариуцлага тооцох албан шаардлага 2.** ТУЗ-ийн гишүүдэд олгосон жилийн үр дүнгийн нэмэгдлийг барагдуулаагүй 30.9 сая төгрөг, Агуулахад байгаа ашигладаггүй бараа материалыг зарж борлуулах ажил хийгдээгүй, тайлант оны 587.6 сая төгрөгийн бараа зарлага гараагүй.
- **Зөвлөмж 5.** Санхүүгийн программыг солих, Дундаж цалин хөлс тооцох аргачлалыг тодорхой болгох, Ажилчдын гарт олгох цалингаас арилжааны банк фондын суутгалыг хийж байгааг шийдвэрлэх, Хугацаандаа бараа материалаа нийлүүлээгүй бэлтгэн нийлүүлэгчид гэрээний дагуу алданги тооцоогүй 3.6 сая төгрөг, Менежментийн төлбөр тайлант жилийн борлуулалтын орлогын 2 хувиар тооцож байгаа нь санхүүгийн чадварт муугаар нөлөөлж байна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлантай холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн аудитын хорооны дарга Б.Чойжил танилцуулна. Та танилцуулгаа хийнэ үү.

Б.Чойжил / Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн: Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дүгээр тогтоолыг танилцуулав.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигч нарт Компанийн 2024 оны санхүүгийн тайлантай холбоотой асуулт, санал байна уу ?

н.Алтан-Очир /Хувьцаа эзэмшигч/: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын материалын 4 болон 5 дах асуудлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл нь хавсаргагдаагүй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн хүний материал нь хавсаргагдаагүй байна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу 4 болон 5 дах асуудал хэлэлцэх үед танилцуулга материалууд тавигдана.

н.Алтан-Очир /Хувьцаа эзэмшигч/: За тэгвэл санхүүгийн тайлантай холбоотой асуулт асууя. Арилжааны банк ажилчдад олгож буй цалингаас фондын суутгал хийж байгаа асуудлыг тодруулж өгөөч. Хоёрдугаарт нь шилэн дансны тухай хуулиар компанийн санхүүгийн мэдээлэл олон нийтэд ил тод нээлттэй тавигдаж байна уу үгүй юу ? сая тайлант огт дурдагдсангүй. Мөн санхүүгийн программ солих асуудал яригдаж байна. Одоо ямар программ хэрэглэж байгаа вэ ? ямар программаар солих гэж байгаа вэ ? эсхүл Эрдэнэс Монгол ХХК-иас санхүүгийн программыг санал болгосон юм уу ?

Б.Наранбаатар /"Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч/: Арилжааны банк ажилчдад олгож буй цалингаас фондын суутгал хийж байгаа асуудал дээр бол манай уурхайн хэсэг нэгжүүд сар болгон тусдаа фонд үүсгэж явдаг энэхүү фондын суутгалын жагсаалтыг арилжааны банканд өгөхөөр тухайн ажилтны цалингаас суутгал хийгдээд байдаг. Тэгэхээр аудитын байгууллагаас ажилчдын цалин ажилчдын дансанд орсны дараа тухайн суутгал нь хийгдэх ёстой гэж хэлсэн тул энэ сарын цалингаас эхлээд ажилчдын цалинд орсны дараа суутгал хийгдэхээр тохиролцоонд хүрсэн. Шилэн дансны тайлагналтын хувьд 2024 онд захирлын тушаалаар шилэн дансанд оруулах мэдээллийг холбогдох мэдээлэл хариуцсан нэгж болгонд нь даалгаад одоо бол шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулаад ажиллаж байна. Санхүүгийн программын хувьд манай компани 2008 онд интерактив компаниас худалдан авсан бөгөөд тус компаниас огт шинэчлэлт болон өөрчлөлтийг хийдэггүй ийм учраас санхүүгийн программыг орчин үед хэрэглэгдэж буй программаар солих шаардлагатай талаар зөвлөсөн. 2025 оны Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөвлөгөөнд нэгдлийн хэмжээнд санхүүгийн программыг нэгэн адил байхаар шинэчлэх ажил хийгдэж байна.

Н.Бурмаа /Хувьцаа эзэмшигч/: Компани улсад өртэй гэж гарсан байна энэ сонин байна уул нь компани чинь улсад маш их ажил хийж өгч, мөнгө төвлөрүүлж байхад яагаад өртэй гардаг билээ ?

Б.Наранбаатар /"Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч/: Компанийн нийт өр төлбөрийн хэмжээ 258.6 тэрбум төгрөг байгаа, сая хувьцаа эзэмшигчийн асуусан 11.6 сая төгрөгийн татварын өр бол өр төлбөр дээр нэмэгдсэн бөгөөд энэхүү өр нь 2020-2022 онд татварын өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүйтэй холбоотой торгууль ногдуулсан. Ер нь өр төлбөр яагаад үүссэн вэ гэхээр компани сүүлийн хэдэн жил байнга алдагдалтай ажиллаж мөнгөн хөрөнгийн дутагдалд орж тус дутагдлыг нөхөхийн тулд зээл авч ирсэн, харин ашигтай ажилласан тохиолдолд зээлийн төлөлтийг хийх замаар ажиллаж ирсэн. Иймд цаашид ашигтай ажиллавал өр төлбөр бууруулах байдлаар ажиллаад явна.

М.Отгонбаяр /Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Сая компанийн аудитын тайлан дээр гарч байна л даа. Энэ толгой компанийн менежментийн төлбөр, энэ менежментийн төлбөрийг өөрчлөх багасгах тал дээр компанид ямар санал байна. Мөн Эрдэнэс Монгол ХХК толгой компани энэ тал дээр ямар бодолтой байна. Компанийн санхүүгийн дарамтыг багасгах ямар арга хэмжээ авах уу ?

Б.Наранбаатар /"Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч/: Менежментийн төлбөрийг бол гэрээ хийж ажилладаг. Менежментийн төлбөрийг Монгол Улсын Засгийн газраас батлаад Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд борлуулалтын орлогын 2 хүртэл хувиар гээд заагаад өгчихсөн байдаг. Мөн Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор охин компаниудаас борлуулалтын орлогын 2 хувиар тооцож авна гэсэн байдаг тул бид үйл ажиллагааны зардал болон өглөг тал дээр суугаад явдаг. 2024 оны менежментийн төлбөр бол 4.9 тэрбум төрөг байгаа.

Ц.Төгсбуян /Эрдэнэс Монгол ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Санхүүгийн алдагдалтай ажиллагаатай холбоотой асуулт гэж ойлголоо. Сая эрчим хүчний зохицуулах хорооноос нүүрсний үнийг нэмснээр Багануур болон Шивээ-Овоо ХК-ийн үйл ажиллагаа, алдагдал багсаж ашигтай ажиллах чиглэл рүү явж байгаа. Эрдэнэс Монгол ХХК-ийн менежментийг төлбөрийг бол 2 хувиар тооцож авч байгаа тул төлбөрийг эргээд 6 байршилд Үйлдвэр технологийн парк барих ажилд зарцуулаад явж байгаа бөгөөд үүний нэг нь Багануурыг түшиглэсэн Багануур Үйлдвэр технологийн парк тул бид эргээд хөрөнгө оруулалтаа Багануур руу чиглүүлж байгаа гэж ойлгож болно.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Өнөөдрийн хурлаар нийт 6 асуудал хэлэлцсэний дараа 20 минутын завсарлага байгаа тус завсарлагааны үеэр тооллогын комиссоос хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй заавар, зөвлөгөөг өгөх болно. За дараагийн асуудал Компанийн хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Аудитын хорооны дарга Б.Чойжил танилцуулна.

Б.Чойжил / Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн: Компанийн хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр болох Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар тогтоолыг танилцуулав.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг зөвхөн танилцах бөгөөд энэ асуудалтай холбоотой тогтоол гаргахгүй тул дараагийн асуудалдаа оръё, Хэлэлцэх асуудал 4 Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Дондогмаа танилцуулна.

Ч.Дондогмаа / Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/: "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас анхлан

компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж сонгогдон 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дахин компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэхээр дараах бүрэлдэхүүнтэй сонгогдож компанийн удирдлага зохион байгуулалтыг хангаж ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч Ч.Дондогмаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хорооны даргаар Б.Чойжил, Цалин урамшууллын хорооны даргаар Ц.Болдбаатар, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Б.Гэрлээ нарийн бичгийн даргаар Б.Жавхлан нар тус тус ажилласан. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр ажилласан Ө.Гэрэлт-Од, Б.Мөнхзаяа нар нь өөрсдийн салбарын мэдлэг, ур чадвараараа хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд компанийн үйл ажиллагааны онцлогийг ойлгож, цаашдын тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүрэн дэмжсэн хараат бус гишүүний чиг үүргийг зохих ёсоор биелүүлж ажилласныг дурдах нь зүйтэй.

2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдож ажиллаж буй Төлөөлөл удирдах зөвлөл нь 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийт 31 удаа 82 хувийн дундаж ирцтэйгээр хуралдаж 48 асуудлыг эцэслэн шийдвэрлэж 40 тогтоол гаргаж ажилласан байна.

Онцлох шийдвэрүүд: "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн түүхэнд анх удаа тухайн ондоо Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэх асуудлын ерөнхий төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан нийт 28 асуудлаас 25 асуудлыг шийдвэрлэж амжилттай ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай"-ийн хүрээнд "Багануур" ХК-ийн охин компани болох "Багануур Илч" ХХК-ийн үйл ажиллагаа бүхэлдээ зогссон. Гэвч 2018 оноос хойш 6 жилийн хугацаанд тус компани нь үндсэн үйл ажиллагаа явуулахгүйгээр жил бүр шаардлагагүй зардал гаргаж алдагдалтай ажиллаж байсан тул тус компанийн үйл ажиллагааг зогсоож толгой компани болох "Багануур" ХК-д нэгтгэж шийдвэрлэсэн. 2024 онд "Багануур" ХК түүхэндээ хамгийн өндөр буюу 4.9 саятн нүүрс олборлон борлуулж, 5 жилийн дараа анх удаа 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан тул 20 жилийн дараа анх удаа хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Компанийн ажилтнуудын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах зорилгоор Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журмыг 10 жилийн дараа шинэчлэн баталж, хамрах хүрээг сургалтын тэтгэлэг олгох боломжоор өргөжүүлснээр нийт 23 ажилтанд санхүүгийн дэмжлэг, оюутан сурагчид сургалтын тэтгэлэг олгосон байна. Компанийн засаглалыг сайжруулах, компанийн засаглалын кодексийн оноог нэмэгдүүлэх зорилгоор Компанийн заламж халааны бодлогын баримт бичиг, Комплайнсын хяналтын загварыг анх удаа баталж, компанийн хяналт, залгамж халааны анхдагч бодлогын баримт бичгийг баталж мөрдүүлж байна. Компанийн санхүүгийн тайлан бүртгэлийг оновчтой болгох зорилгоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд

шинэчлэн тусгах, Үндсэн хөрөнгийг бүртгэлд бүртгэгдээгүй 8 хөрөнгийн холбогдох хууль журмын дагуу үнэлж бүртгэх, "Багануур сувилал" ХХК болон "Багануур" ХК-ийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн зөрүүг арилгах асуудлуудыг тус тус шийдвэрлэж. Компанийн санхүүгийн болон хөрөнгийн бүртгэл тайлагналтыг сайжруулсан.

"Багануур Сувилал" ХХК болон "Багануур" ХК-ийн хооронд хуримтлагдсан ногдол ашгийг хоорондын тооцоонд тусгах замаар хуримтлагдсан ногдол ашгийг шийдвэрлэсэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хорооны гишүүдийг улируулан сонгосон бөгөөд Компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, хороодын үйл ажиллагааны журамд заасны дагуу ажилласан. Нэр дэвшүүлэх Хорооны бүрэлдэхүүнд дарга Б.Гэрлээ гишүүд Б.Мөнхзаяа, Б.Чойжил нар ажилласан. Тус хороо нийтдээ 8 удаа хуралдаж "Комплайнсын хяналтын заавар, бүтэц", "Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого"-ын баримт бичгийн засан сайжруулж, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг дүгнэж, компанийн зохион байгуулалтын бүтцийн саналыг боловсруулж холбогдох мэргэжлийн зөвлөгөөг компанийн удирдлагын багт өгч ажилласан. Цалин урамшууллын Хорооны бүрэлдэхүүнд дарга Ц.Болдбаатар гишүүд Ө.Гэрэлт-Од, М.Отгонбаяр нар ажилласан. Тус хороо нийтдээ 8 удаа хуралдаж Компанийн ажилтнуудын шинэ цалингийн сүлжлийг компанид мөрдүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлж, үйлдвэрчний эвлэлийн санал компанийн удирдлагуудын саналыг харгалзан компанийн ажилчдын цалинг нэмэгдүүлэх боломжийг компанийг мөнгөн урсгал, санхүүгийн чадамжид тохируулан нэмэгдүүлж, 2024 онд ашигтай ажилласан тул компанийн ажилчдад үр дүнгийн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхээ олгох хуваарийг батлахыг компанийн удирдлагуудад үүрэг болгон хамтран ажилласан. Аудитын Хорооны бүрэлдэхүүнд дарга Б.Чойжил гишүүд Ө.Гэрэлт-Од, Д.Эрдэнэбаяр нар ажилласан. Тус хороо нийтдээ 15 удаа хуралдаж ногдол ашиг тараах асуудлыг хэлэлцэж, бизнес төлөвлөгөө боловсруулах, засан сайжруулах саналыг боловсруулж, Эдийн засаг нийгмийн хөгжлийн санг хэрхэн зөв удирдан чиглүүлэх болон заавал данстай байх үндсэн шаардлагыг компанийн удирдлагуудад зөвлөмж өгч, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, санхүүгийн тайлагналтыг үнэн зөв алдаагүй болгох чиглэлд зөвлөмж өгч, "Багануур Илч" ХХК-ийн үйл ажиллагааны алдагдлыг тодорхойлж, үйл ажиллагааг зогсоож цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг компанийн удирдлагуудад өгч, мэргэжлийн арга зүйн шаардлага, саналыг тус бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын харилцан уялдаа холбоотой ажиллах нөхцөлийг ажлыг гүйцэтгэсэн байна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцууллаа. Энэ асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоол гарахгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас асууж тодруулах зүйл байвал асуугаарай.

н.Нарантунгалаг /Хувьцаа эзэмшигч/: Компанийн захирал тайлан тавьж байхдаа нийт ажилтнууд маань 50 хувь нь залуучууд болж байгаа тухай ярьсан. Хүний нөөц дээр бол Төлөөлөн удирдах зөвлөл нь ямар бодлого баримталж байна вэ ? сая компанийн бүтэц батлагдсан байсан тус бүтцэд энэ менежерүүд тусгагдсан байна. Чанарын менежер, бүтээмжийн менежер гээд байгаа хүмүүс нь мэргэжлийн бус хүмүүс томилогдоод байна. мөн цалин нэмэгдсэн ч инфляц дагаад нэмэгдээд байгаа учир хангалттай биш байна. Энэ тал дээр Монгол Улсын Засгийн газар цаашлаад төртэй холбоотой яаж ажиллана гэж харж байгаа вэ ?

Ч.Дондогмаа /Хувьцаа эзэмшигч/: Нарантунгалаг хувьцаа эзэмшигчийн асуултад хариулъя, Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьд Компанийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх холбогдох журмыг баталж мөрдүүлж ажиллаж байгаа талаар би танилцуулга дээрээ дурдсан Эдийн засгийн нийгмийн хөгжлийн санг 10 жилийн дараа хамрах хүрээг нь өргөжүүлж баталсан. Түүнчлэн бусад уул уурхайн компаниудын жишигтэй харилцуулах замаар 2023 он 2024 он 2025 онд үе шаттай цалинг 50 хүртэл хувь нэмэгдүүлсэн. Толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн ирүүлсэн чиглэлийн дагуу компанийн бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд энэ бүтцийн дагуу компанид 3 чиглэлийн менежер томилох шийдвэр өгсөн. Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, Толгой компанийн чиглэл хуульд нийцсэн эсэх дээр төлөөлөн удирдах зөвлөл хариу өгөх боломжгүй буюу төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч нар маань толгой компаниас ирүүлсэн удирдамжийн дагуу саналаа өгч оролцсон байгаа.

н.Ганболд /Хувьцаа эзэмшигч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга ямар туршлагатай хүн вэ ? ямар хүн вэ ? яагаад гэвэл саналын хуудас дээр ногдол ашиг авах асуудал дээр санал авахаар орсон алдаатай зүйлс байна.

Ч.Дондогмаа /Хувьцаа эзэмшигч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга 2023 оны 04 дүгээр сарын хувьцаа эзэмшигчдийн хурлын дараа томилогдсон Б.Жавхлан гэж хүн байгаа. Монгол Улсын Их Сургуулийг төгссөн хуульч мэргэжилтэй сүүлийн 2 удаагийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулсан байгаа.

Б.Жавхлан /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/: За би өөрийгөө танилцуулъя, намайг Б.Жавхлан гэдэг одоо Багануур ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Эрх зүйч мэргэжилтэй, Хуульч өмгөөлөгчийн тусгай зөвшөөрөлтэй 2023 оны 6 сард томилогдсон хүн байна. Таны хэлсэн асуудлыг цаашид анхаарч үзье.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Өөр асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа оръё, хэлэлцэх асуудал 5 компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/: 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 25/05 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлд хаягласан албан бичгийг хувьцаа эзэмшигч болох Монголиан нейшнл коүл корпорейшн ХХК-иас ирүүлсэн. Тус саналд дараах дүрмийн өөрчлөлтийн агуулга тусгагдсан байна.

- Компанийн дүрмийн 3.3.2 дах заалтын "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 12 (арван хоёр) гишүүнтэй байх бөгөөд 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна." гэсэн заалтын 12 гэснийг 13 болгож өөрчилж "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 13 (арван гурав) гишүүнтэй байх бөгөөд 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна." гэж өөрчлөх санал юм.

Тус саналын дагуу дүрэмд өөрчлөлт оруулснаар Компанийн тухай хуулийн 75.4 дэх хэсэг "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.", компанийн дүрмийн Компанийн дүрмийн 3.3.2 дах заалтын "...1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна." гэж тус тус заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо 13 болсноор хууль болон дүрэмд заасан хараат бус гишүүний заавал байх квот нэмэгдэж Хараат бус гишүүний тоо нэгээр нэмэгдэж нийт 5 хараат бус гишүүнтэй болно.

Толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн зүгээс компанийн дүрэм өөрчлөлт оруулах дараах 2 саналыг ирүүлсэн.

- Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад "Компанийн гүйцэтгэх удирдлага албан томилолтоор ажиллах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлөөр, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн албан томилолтоор ажиллах тохиолдолд толгой компанийн Гүйцэтгэх удирдлагаар томилолтын удирдамжийг батлуулж, батлагдсан удирдамжийн дагуу ажиллана." гэж заасан заалтаас "гишүүн" гэснийг "дарга" гэж өөрчлөх;

Энэхүү өөрчлөлтийг оруулснаар охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гадаадад томилолтоор ажиллахдаа толгой компанийн гүйцэтгэх захирлаас удирдамж авахгүй, зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга л удирдамж батлуулж, удирдамжийн дагуу ажиллах нөхцөл бүрдэнэ.

- Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад "Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүтцийн нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно." гэж заасан заалтаас "бүтцийн нэгжийн" гэснийг "газар, хэлтсийн" гэж өөрчлөх.

Энэ өөрчлөлтийг оруулснаар компанийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоо багатай бүтцийн жижиг нэгж болох алба, цөх зэргийн удирдлагууд эрх бүхий албан тушаалтанд тооцогдохгүй. Ингэснээр тухайн жижиг нэгжүүдийн

удирдах ажилтнууд ХАСУМ, ХАСХОМ хянуулаагүй гэх үндэслэлээр хариуцлага хүлээх эрсдэлгүй болох юм.

н.Ганбаяр /хувьцаа эзэмшигч/: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал бэлдэхдээ урьдчилж өгөх ёстой. Энэ тал дээр дараагийн удаадаа анхаараарай Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаа. Харин дүрмийн санал дээр дэмжиж байна. Мөн Хараат бус гишүүний тоо нэмэгдэхээр нэг хүн сонгогдоно гэж ойлгож байна. Тэр хүнийх нь танилцуулга материал байхгүй байна. Эсхүл бүх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд улирч сонгогдох юм уу бүгдээрээ солигдох юм уу энэ тал дээр мэдээлэл алга. Өөр асуулт алга.

Б.Жавхлан /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг би танилцууллаа. Харин хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах асуудлыг дараагийн асуудлаар нэр дэвшүүлэх хорооноос танилцуулна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Өөр асуулт байна уу? байхгүй бол дараагийн асуудалдаа оръё, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга саяны хэлснийг тэмдэглэж аваад дараагийн удаа анхаарч ажиллаарай. За 6 дах асуудал Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх асуудлын талаарх дүгнэлт, зөвлөмжийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны гишүүн Б.Чойжил танилцуулна.

Б.Чойжил / Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/: Багануур ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах асуудлыг хараат бус гишүүний сонгон шалгаруулалт болон хувийн болон төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс ирүүлсэн чиглэлийн хүрээнд хэлэлцсэн.

"Багануур" ХК нь хүчин төгөлдөр дүрмийн дагуу нийт 12 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй бөгөөд 2 гишүүнийг "Монголиан нэшнл коөл корпрейшн" ХХК-ийн ирүүлсэн саналын хүрээнд, 6 гишүүнийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 2.1.3 дах хэсэгт "төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээнд тохирох тооны гишүүн (цаашид "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн" гэх)-ийг томилох, чөлөөлөх, эсхүл томилох, чөлөөлөх саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХК-ийн ирүүлсэн саналын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэнэ.

"Багануур" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо компанийн тухай хуулийн 79.1 дэх заалт "Энэ хуулийн 81.2-т заасан нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний

нэрийг дэвшүүлнэ." гэж заасны дагуу хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг Компанийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан журам, "Багануур" ХК-ийн дүрмийн дагуу зохион байгуулсан.

"Багануур" ХК-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн нэр дэвшүүлэх хорооны хурлаас Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар журамд заасны дагуу нэр дэвшигчдийн материал хүлээн авах зарыг аар өдөр тутмын сонин болох Монголын Мэдээ, Өнөөдөр, Өглөөний сонин, Зууны мэдээ, Өдрийн сонин гэсэн нийт 5 сониноор зарлаж, Компанийн албан ёсны олон нийтийн цахим сүлжээ дэх хаяг, Эрдэнэс Монгол компанийн албан ёсны олон нийтийн цахим сүлжээ дэх хаяг, уул уурхайн салбарын мэдээллийг хамгийн олон харилцагчид хүргэдэг Майнинг Монголиа олон нийтийн цахим сүлжээний хаягаар тус тус 3 хоногийн зайтай давтан нийт 9 хоног олон нийтэд мэдээлсэн.

"Багануур" ХК-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарын дагуу нийт 19 оролцогчийн материал ирсэн. Үүнээс 3 оролцогчийн материал бүрдүүлбэр хангаагүй, 3 оролцогч нийтлэг шаардлага хангаагүй, үлдсэн 16 оролцогч тусгай шаардлагын хүрээнд зохих оноог авч хамгийн өндөр оноо авсан 5 хүнийг нэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох журмын дагуу Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХК-ийн ирүүлсэн саналын дагуу дараах гишүүд:

- П.Баттөр
- Б.Гэрлээ
- Ч.Дондогмаа
- И.Лувсанцэрэн
- Э.Түвшин
- Г.Намчинсүрэн

"Монголиан нэшнл коэл корпорејшн" ХХК-ийн ирүүлсэн саналын дагуу дараах гишүүд:

- М.Отгонбаяр /"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК-ийн төлөөлөл/
- Шижир /"Монголиан нейшнл коал корпорейшн" ХХК-ийн төлөөлөл/

Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлж бай хараат бус гишүүд.

- Д.Энхжаргал
- Н.Зоригтсайхан
- Б.Энхтуяа
- С.Цолмон
- Б.Даваатогтох

"Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос гарсан дээрх дүгнэлтийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцууллаа.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг танилцуулсан нэр дэвшүүлэх хорооны санал дүгнэлттэй холбоотой асуулт, санал байна уу ?

Э.Шижир / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: Нэр дэвшигч нарыг танилцууллаа, нийт 19 хүн материал өгсөн юм байна. Үүнээс 3 нь бүрдэл хангаагүй, 3 нь шаардлага хангаагүй хүмүүс байна. Үлдсэн 13 нь шаардлага хангасан хүн байна. Иймд Хувьцаа эзэмшигчдийн хуралд шаардлага хангасан бүх хүн буюу 13 хүнийг оруулж хувьцаа эзэмшигч нар түүнээс 5 хүнд санал өгч санал хураалгах ёстой. Энэ бол хувьцаа эзэмшигчийн эрх, харин нэр дэвшүүлэх хороо бол зөвхөн бүрдэл болон шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах ёстой бусад сонгох сонгогдох эрхийн хувьд хувьцаа эзэмшигч нар өөрсдөө шийдэх ёстой. Иймд тус шаардлага хангасан 13 хүний нэрийг бүгдийг нь уншиж танилцуулж өгнө үү.

н.Ганбаяр /хувьцаа эзэмшигч/: Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-иас нэр дэвшиж буй М.Отгонбаяр нь хуучин компанид ажиллаж байсан бил үү ? Мөн энэ хүмүүсийн дэлгэрэнгүй анкетыг танилцуулах нь зүйтэй байх.

н.Нарантунгалаг /Хувьцаа эзэмшигч/: Компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах тал дээр ямар саналтай байгаа вэ ? бид нараас ядаж нэг гишүүн байж болохгүй байсан уу ?

М.Отгонбаяр / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: Би 2012 оноос 2016 онд Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшиж буй иргэдийн нэр албан тушаал товч танилцуулгыг дэлгэцэн дээр үзүүлэх үү ?

Б.Чойжил / Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/: Нэр дэвшүүлэх хорооны дарга дээр маань танилцуулга материалууд нь байгаа бөгөөд манай дарга Эрдэнэс Таван Толгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа. Тус хурал нь одоо дууссан тул ирээд нэр дэвшигчдийн материалыг танилцуулах болно. Төрийн төлөөллийн хувьд Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу салбарын холбогдох яамдын төлөөллийг нэрийг ирүүлсний үндсэн дээр оруулж ирсэн. Хараат бус дээр бол нийтлэг шаардлага хангаад үүний дараа тусгай шаардлага хангасан байдлаас нь оноо өгөөд хамгийн өндөр оноо авсан 5 нэр дэвшигчийг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний квотод тохируулж оруулж ирж байгаа юм.

Э.Шижир / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: Ердийн гишүүдийн хувьд хувьцаа эзэмшигч нар өөрсдийн хувьцааны тоо хэмжээний

хүрээнд ногдох хүнийг шууд нэр дэвшүүлж байгаа. Харин Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус дээр өөр буюу алинаас нь ч хамааралгүй байх ёстой, өөрөөр хэлбэл тэр зар болон нээлттэй сонгон шалгаруулалтаар нэрс нь орж ирээд Нэр дэвшүүлэх хороо ур чадварынх нь хувьд болон бичиг баримтын бүрдүүлбэрийн хүрээнд шалгаад шалгуур хангаж буй бүх хүнийг оруулж ирэх ёстой. Мөн сая жижиг хувьцаа эзэмшигч нараас өөрсдийнхөө дундаас хүн ооруулъя гэж ярьж байна. Та бүхэнд хараат бус гишүүнд материалаа өгөх эрх нь нээлттэй бөгөөд хараат бус гишүүнээр дамжуулан Төлөөлөн удирдах зөвлөлд оролцох боломжтой.

Б.Чойжил / Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/: Компанийн тухай хуулийн 81.5.3 дах хэсэгт нэр дэвшүүлэх хорооны эрх үүргийг тогтоосон бөгөөд тус заалтад нэр дэвшүүлэх хороо хараат бус гишүүнд нэр дэвшигчийг шууд хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлнэ гэж заасны дагуу шууд л оруулж ирж байгаа юм.

Э.Шижир / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: Шууд нэр дэвшүүлнэ гэдэг нь Нэр дэвшүүлэх хороо тусгай шаардлагаар хасалт хийнэ гэсэн үг биш, харин шаардлага хангасан бүх нэр дэвшигчдийг ямар нэгэн хасалт хийхгүйгээр шууд оруулна гэсэн үг.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод дүрэм журмаар бүх нэр дэвшигчдийг танилцуулна гэж байдаг уу харин хараат бус гишүүний тоонд тохируулж нэр дэвшүүлнэ гэж байдаг уу ?

Б.Тэнгис /Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөл/: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой ТУЗ-ын хараат бус гишүүний сонгон шалгаруулах журмыг баталсан. Энэ журам дээр төрийн өмчийн оролцоо 50+1 хувийн оролцоотой бол энэ журмыг дагаж мөрдөнө гэж заасан тул Багануур ХК нь тус журмыг дагаж мөрдөнө. Тус журамд хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг явуулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах бүх процессыг тодорхойлсон байдаг.

Ө.Гэрэлт-Од /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/: Зөвхөн энэ асуудал ч биш компанийн засаглалын асуудал дээр байнга асуудал үүсдэг, Багануур ХК бол хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигч нар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээрээ дамжуулж компанийн шийдвэр гаргалтад оролцох ёстой. Яг энэ тохиолдолд Төрийн өмчийн оролцоотой гэдэг байдлаар Засгийн газрын шийдвэрээ барих юм уу хувьцаат компани гэдэг байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл хараат бусаар шийдвэр гаргах юм уу гэж энэ уул нь асуудал биш нэгэнт хувьцаат компани гэсэн бол компанийн тухай хуулиа л дагаж мөрдөх ёстой.

Э.Шижир / Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /: Санал хураалт явагдахын тулд саяны 5 хүн дээр биш 13 хүн дээр санал хураалт явагдах ёстой гэж үзэж байна.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: За хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа хэлж дууслаа, хурлын дэгийн дагуу санал хураалт эхлэхээс өмнө 20 минут завсарлах шаардлагатай. Энэ хооронд Нэр дэвшүүлэх хороо нийтлэг шаардлага хангасан 13 нэр дэвшигчийн материалаа танилцуулах тул хурлын түр завсарлуулъя.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Санал хураалтын өмнө Нэр дэвшүүлэх хороо нийтлэг шаардлага хангасан 13 хүний ажил мэргэжлийн туршлага, нас, ажилласан жил, ажилласан байгууллага овог нэрийн дагуу танилцуулгыг танилцуулав. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа гарган Тооллогын комисст өгөв.

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа:

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоол,

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,934 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 13 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,148,934.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,934 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 13 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл

2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,148,934.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148, 934 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 13 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл

3. Ноогдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга

Зөвшөөрсөн	20,148, 934.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148, 934 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 13 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл

4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай

Зөвшөөрсөн	20,148, 774.00	санал 99.999% хувь
Татгалзсан	160.00	санал 0.001% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,934 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 13 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй байхгүй

Санал өгсөн байдлыг үзвэл

5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Зөвшөөрсөн	20,148,934.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 272,666,680 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,148,934 ширхэг хувьцаа бүхий 261,936,142 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцож Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 61.5%-аар ердийн гишүүдийг сонгох санал хураалт явуулж 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчингүй саналын хуудас 1, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл

6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий ердийн гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

П.Баттөр	20,976,184.0	санал
И.Лувсанцэрэн	20,975,332.0	санал
Э.Түвшин	20,975,492.0	санал
Г.Намчинсүрэн	20,976,184.0	санал
Ч.Дондогмаа	20,975,332.0	санал
Б.Гэрлээ	20,975,332.0	санал
М.Отгонбаяр	17,668,644.0	санал
Э.Шижир	17,667,652.0	санал

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоол

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 272,666,680 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,148,934 ширхэг хувьцаа бүхий 261,936,142 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцож Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 38.5%-аар хараат бус гишүүдийг сонгох санал хураалт явуулж 12 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчингүй саналын хуудас 1, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл:

7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий хараат бус гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

Ө.Гэрэлт-Од	22,083,975.0	санал
Д.Энхжаргал	19,663,538.0	санал
Н.Зоригтсайхан	19,663,835.0	санал
С.Цолмон	19,663,835.0	санал
Б.Даваатогтох	19,663,862.0	санал

Д.Ядамжав /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг сая сонслоо, тус комиссын тогтоолд үндэслэн дараах тогтоолууд гарч байна.

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
3. "Багануур" ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Багануур ХК ийн Хувьцаа эзэмшигчдийн ЭЭЛЖИТ хурал хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж дууслаа.

Хувьцаа эзэмшигчдийн ЭЭЛЖИТ хуралд танхимаар болон цахимаар анхааралтай оролцож, компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, холбогдох мэдээлэлтэй танилцсан хувьцаа эзэмшигч та бүхэндээ компанийн өмнөөс талархсанаа илэрхийлж байна. Монгол Улсын Засгийн газраас төрийн өмчит компаниудын засаглал, үйл ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч "Эрдэнэс Монгол" Нэгдлийг 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд төр, засгийн бодлого шийдвэрээр дэмжсэн жил байлаа. 2024 оныг "Эрдэнэс Монгол" Нэгдэл "Хэрэгжилт-үр дүнгийн" жил болгон зарлаж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үндсэн зорилгынхоо хүрээнд нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын засаглал, менежмент, үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах,

нэгдсэн бодлого, стратегийн чиглэлээр ханган ажиллаж, стратеги төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтээ Монгол Улсын Засгийн газарт танилцуулж "Сайн" үнэлгээ авсан. Нэгдлийн бүрэлдэхүүн компани болох "Багануур" ХК нь дээрх амжилтыг бататган 2024 онд 49 жилийн түүхэнд хамгийн их буюу 4,957.4 мянган тонн нүүрс олборлон, 4,916.1 мянган тонн нүүрс борлуулж 18 жилийн хугацаанд хуримтлагдсан нийгмийн даатгалын 24 тэрбум төгрөг, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны зээлээр хэрэгжүүлсэн техник шинэчлэлийн 23.5 тэрбум төгрөгийн өр төлбөрүүдийг тус тус бүрэн төлж, 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, улс орон нутгийн төсөвт 50.7 тэрбум төгрөгийг төвлөрүүллээ. Мөн 2024 оны 8 сард нэгдлийн бүрэлдэхүүн компани, харьяа хуулийн этгээдүүдийн "Өвөлжилтийн бэлтгэл ажил-2024" балансын хурлыг "Багануур" ХК зохион байгуулах үеэр Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын зарласан "Үндэсний баялгийн санг бүрдүүлэх" реформ, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2024 оны цэвэр ашгаасаа хуримтлалын санд тодорхой төгрөгийг төвлөрүүлсэн зэргийг онцлон тэмдэглэмээр байна. "Эрдэнэс Монгол" ХХК-аас жил бүр нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын ололт амжилтыг дүгнэж "Эрдэнэсийн цом"-ын эздийг тодруулдаг. Эрдэнэс Монгол нэгдлийн бүрэлдэхүүн, Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувийг дангаараа хангаж, улс орныхоо эрчим хүч, дулаан хангамжийн системд томоохон хувь нэмэр оруулан ажиллаж байгаа "Багануур" ХК-ийг 2024 оны "Алтан эрдэнийн цом"-ын эзнээр шалгаруулсан байна. 2024 онд эрчим хүчний нүүрсний найдвартай, тогтвортой нийлүүлэлтийг хангах үндсэн зорилтоо хэрэгжүүлэн ажиллаж, үүний үр дүнд үйлдвэрлэл болон болон санхүүгийн түүхэн амжилт гаргасан нь уурхайчин хамт олны хичээл зүтгэл, хариуцлага, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, төлөвлөлтийн үр дүн гэдгийг мөн "ОНЦЛОН ТЭМДЭГ"-лэмээр байна. "Эрдэнэс Монгол" Нэгдлээс 2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын 2024-2028 онуудад хэрэгжүүлэх 14 мега төсөл, "Эрдэнэс Монгол" Нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд туссан "Багануур" УТП-ийн төслийг хэрэгжүүлэхэд "Багануур" ХК-ийн уурхайчин хамт олны мэдлэг туршлага, үүрэг хариуцлага улам бүр нэмэгдэж, Монгол Улсын эрчим хүчний хэрэглээг хангахаас гадна, Улаанбаатар хотын иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, агаарын бохирдлыг бууруулах их үйлсэд хамтран зүтгэж, манлайлж оролцоно гэдэгт итгэлтэй байна.

2025 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай хуралдаж дууслаа. Идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

Хурал 14:23 цагт дуусав.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Д.ЯДАМЖАВ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга *Б. Жавхлан* Б.Жавхлан